

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН 01 ДҮГЭЭР ХУРАЛ**

Хурлыг 2014 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 15 цаг 00 минутад эхэлж, 16 цаг 45 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын өрөөнд болж, 1 цаг 45 минут хуралдав.

Д/д	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1.	“Улсын сайн малчин цол”-оор шагнуулахаар аймгаас тодорхойлогдож байгаа малчдын үзүүлэлт	Онооны жагсаалтаар эхний 3 байрт шалгарсан Үенч сумын Жаргалан багийн малчин Хинатын Бөрбай, Чандмань сумын Баянхайрхан багийн малчин Дашдоржийн Төрбат, Алтай сумын Алтангадас багийн малчин Цэвээний Сонинпил нарын тодорхойлолтыг яаралтай үнэн зөвөөр шинэчилж бүрдүүлэн “Улсын сайн малчин” цол тэмдгээр шагнуулахаар, “Алтан төлийн эзэн” шагналд Манхан сумын Зэрэг гол багийн малчин Авираагийн Төртогтохын тодорхойлолтыг тус тус уламжлахаар Засаг даргын зөвлөлийн гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэв.

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН 02 ДУГААР ХУРАЛ**

Хурлыг 2014 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 16 цаг 08 минутад эхэлж, 18 цаг 30 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын өрөөнд болж, 2 цаг 38 минут хуралдав.

Д/д	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
	Мо Эн Ко компанитай байгуулах гэрээний төсөл	Гишүүдийн оруулсан саналыг нэмж боловсруулаад Мо Эн Ко компанид танилцуулаад саналыг нь тусган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд өргөн барьж хэлэлцүүлэхээр шийдвэрлэв.
	Аймгийн сайн малчин, тэргүүний тариаланч шалгаруулах тухай	Аймгийн сайн малчин тэргүүний тариаланч шалгаруулах журмын шаардлага хангасан 26 малчин, 3 тариаланчийг шалгаруулах Засаг даргын захирамжийн төслийн зөвлөлийн гишүүд санал нэгтэй дэмжив.
	Дарви сумын нутагт отрын бүс нутаг тогтоох	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд өргөн барихыг аймгийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын дарга З.Лувсанд үүрэг болгов.

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН 03 ДУГААР ХУРАЛ**

Хурлыг 2014 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 16 цаг 30 минутад эхэлж, 17 цаг 35 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын өрөөнд болж, 1 цаг 05 минут хуралдав.

д/д	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1.	1.Ерөнхийлөгчийн зарлиг засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцын тухай	1.Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн 267 заалтыг хяналтанд авч хэрэгжилтэнд хяналт, шинжилгээ-үнэлгээ хийж, жилийн эцсийн байдлаар биелэлтийн явц 84.0 хувийн хэрэгжилттэй байна гэж шийдвэрлэв.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН 04 ДҮГЭЭР ХУРАЛ

Хурлыг 2014 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 17 цаг 20 минутад эхэлж, 20 цаг 00 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын өрөөнд болж, 2 цаг 40 минут хуралдав.

Д/д	Хэлэлцэх асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	“Төрийн албан хаагчдыг чадавхижуулах” сургалтын талаарх мэдээлэл	Төрийн албан хаагчдыг идэвхитэй оролцуулах тухай аймгийн Засаг даргын захирамж гаргаж сум, байгууллагуудад танилцуулан зохион байгуулахыг Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Д.Дэлгэрбаярт үүрэг болгов.
2	“Аймгийн алдарт уяачдыг шалгаруулах” болзолыг танилцуулах	Хэлэлцэх асуудлыг дахин сайтар боловсруулж дараагийн Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр хойшлуулав.
3	Хөрөнгө гаргах тухай	Хөрөнгө гаргах захирамжинд 2781750 төгрөгийг зарцуулж аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг зөвшөөрч олонхийн саналаар шийдвэрлэв.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН 05 ДУГААР ХУРАЛ

Хурлыг 2014 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 14 цаг 30 минутад эхэлж, 16 цаг 50 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын өрөөнд болж, 2 цаг 20 минут хуралдав.

Д/д	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	“Аймгийн алдарт уяачдыг шалгаруулах” болзолыг танилцуулах	Аймгийн Засаг даргын захирамжаар 21 иргэнд аймгийн алдарт уяач цол олгох захирамж гаргахаар шийдвэрлэв.

2	Могой жилийн аймгийн аварга байгууллага шалгаруулах тухай	Тэргүүн байр эзэлсэн аймгийн Хөдөлмөрийн хэлтсийг 3000000 төгрөг, дэд байр эзэлсэн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрыг 2000000 төгрөг, гутгаар байр эзэлсэн Стандартчлал хэмжилзүйн хэлтсийг 1000000 төгрөгөөр шагнаж, Тэргүүн байр эзэлсэн байгууллагын даргыг 1 сарын үндсэн цалингаар, дэд байр эзэлсэн байгууллагын даргыг үндсэн цалингийн 75 хувиар, гутгаар байр эзэлсэн байгууллагын даргыг үндсэн цалингийн 50 хувиар урамшуулахаар тус тус шийдвэрлэв.
3	Могой жилийн аймгийн аварга сум шалгаруулах тухай	Тэргүүн байр эзэлсэн Үенч сумыг 5000 000 төгрөг, дэд байр эзэлсэн Зэрэг сумыг 4000 000 төгрөг, гутгаар байр эзэлсэн Жаргалант сумыг 3000 000 төгрөг Тэргүүн байр эзэлсэн Жаргалант сумын Жаргалан, дэд байр эзэлсэн Чандмань сумын Жаргалант, гутгаар байр эзэлсэн Алтай сумын Тахилт багийг тус бүр 1500 000 төгрөгөөр шагнаж, Тэргүүн байр эзэлсэн сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга, байгууллагын дарга, багийн Засаг дарга нарыг 1 сарын үндсэн цалингаар, дэд байр эзэлсэн сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга, байгууллагын дарга, багийн Засаг дарга нарыг үндсэн цалингийн 75 хувиар, гутгаар байр эзэлсэн сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга, байгууллагын дарга, багийн Засаг дарга нарыг үндсэн цалингийн 50 хувиар урамшуулахаар тус тус шийдвэрлэв.

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН 06 ДУГААР ХУРАЛ**

Хурлыг 2014 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 08 цаг 50 минутад эхэлж, 09 цаг 41 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын өрөөнд болж, 51 минут хуралдав.

д\д	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1.	Аймгийн есөн алдартан шалгаруулах тухай	1.Боловсролын салбарын алдартнаар Н.Тэгшжаргалыг, Эрүүл мэндийн салбарын алдартнаар Өрхийн их эмч З.Цоожийг, Дэд бүтцийн салбарын алдартнаар Б.Ганзоригийг, Санхүүгийн салбарын алдартнаар Г.Хандцэцэгийг, Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарын алдартнаар О.Цэнгэлийг, Барилгын салбарын алдартнаар Ё.Бүүвэйбаатарыг, Байгаль орчин, ногоон бизнесийн салбарын алдартнаар Н.Энхмандахыг, Соёл, урлаг, спортын алдартнаар Ц.Батзоригийг, Хуулийн салбарын алдартнаар Д.Эрдэнэчимэг нарыг санал нэгтэй шалгаруулахаар шийдвэрлэв

2.	Хөрөнгө гаргах тухай захирамжийн төсөл	Хөрөнгө гаргах захирамжинд 9131000 төгрөгийг зарцуулж аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг зөвшөөрч олонхийн саналаар шийдвэрлэв.
----	--	---

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН 07 ДУГААР ХУРАЛ

Хурлыг 2014 оны 02 дүгээр сарын 17-ны өдрийн 08 цаг 30 минутад эхэлж, 11 цаг 25 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын өрөөнд болж, 2 цаг 55 минут хуралдав.

д\д	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Хөшөөт төслийг хэрэгжүүлэх талаар Ховд аймгийн баримтлах бодлогын тухай илтгэл	<p>1.Хөшөөт төслийг хэрэгжүүлэх талаар Ховд аймгийн баримтлах бодлогын тухай илтгэлд 2014 оны 1 дүгээр сарын 20-ны байдлаар ашиглалтын болон хайгуулын лицензийн тоо, нүүрс олборолтыг жилийн эцсийн тоог нэмж тусгах саналыг нэгтгэж дахин эцэслэн засварлах</p> <p>2.Ховд аймаг болон МоЭнКо ХХК хоорондын хамран ажиллах гэрээнд гэрээний 11.3-д үл ялгаварлах зарчмаар ногдуулна гэснийг газрын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу ногдуулна гэж өөрчлөх</p> <p>12.3-д Усны тухай Монгол улсын хуулийн 31 дүгээр зүйлд зааснаар төлбөрийг тооцно гэж оруулах 4.4-д хангах чиглэлээр Цагдаагийн байгууллагад чиглэл өгнө гэж</p> <p>18.4 дахь заалтыг хасах</p> <p>15.8-д тусгасан заалт 15.10 дахь заалт давхцаж байгаа учраас 15.10 дахь заалтын гэвч гэдэг үгнээс хойшхи үгүүдийг хасах</p> <p>15.6 гэж заалт нэмж оруулах Үүнд: Аймгийн зүгээс гэрээнд заасан үүргээ биелүүлсэн, компаний зүгээс 2014 оны 12 дугаар сар хүртэл 500 000 тн нүүрс гаргаж чадаагүй тохиолдолд гаргасан нүүрсний хэмжээ хамаарахгүйгээр “Хөшөөт хөгжил” санд 2014 онд шилжүүлэх мөнгийг бүрэн шилжүүлнэ гэсэн санал гарсныг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд өргөн барихыг аймгийн Засаг даргын орлогч М.Амарсанаад үүрэг болгов.</p>
2	Аймгийн сүлд далбаа, бэлэгдэл, шагналуудын загварын тухай илтгэл	<p>Аймгийн сүлд далбаа, бэлэгдэл, шагналуудын загвар төсөлд</p> <p>1.Манай аймгаас өөр газар ургадаггүй Бадамлянхуа цэцгийг аймгийн сүлдэнд оруулах, Галдан бошигт хааны хөргийг оруулахгүй Галдан бошигт гэсэн бичээстэй байх</p> <p>2.Төсөл загвараа ирүүлсэн ахмад багш А.Баасанхүү, Төрийн соёрхолт, уран барималч Л.Ганхуяг, Ховд их сургуулийн багш Д.Гантулга нарын бүтээлийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд өргөн барихыг аймгийн Засаг даргын орлогч Ч.Чинбатад үүрэг болгов.</p>
3	Баяр наадмыг зохион байгуулах хороо байгуулах тухай	Тогтоолын төслийг хэлэлцэж олонхийн саналаар XVII зууны үеийн Монголын төр, шашны нэрт зүтгэлтэн Ойрадын Галдан бошгот хааны мэндэлсний 370 жилийн

		<p>ойн баяр, Баруун бүсийн даншиг наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсгийн даргаар аймгийн Засаг дарга Д.Цэвээнравдан ахалж 21 хүний бүрэлдэхүүнтэй байхаар 9 нь Улаанбаатар хотоос оролцохоор, мөн 9 салбар хороо байгуулагдаж хороо, салбар хороодыг байгууллаа.</p> <ul style="list-style-type: none"> - Хурдан морьдын уралдаан зохион байгуулах салбар хороог 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр -Үндэсний Бөхийн барилдаан зохион байгуулах салбар хороог 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр -Сурын харваа зохион байгуулах салбар хороог 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр -Аж ахуй хариуцсан салбар хороог 13 хүний бүрэлдэхүүнтэйгээр -Урлаг, спортын асуудал хариуцсан салбар хороог 13 хүний бүрэлдэхүүнтэйгээр -Хэв журмын асуудал хариуцсан салбар хороог 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр -Хэвлэл мэдээллийн асуудал хариуцсан салбар хороо, хороог 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр -Ерөнхий зохион байгуулагч бөгөөд салбар хороодыг удирдлага, хамтын ажиллагаагаар хангах , зочид төлөөлөгчдийг хүлээн авч, байрлуулах салбар хороо, хороог 31 хүний бүрэлдэхүүнтэйгээр -Олон улсын эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах салбар хороо, наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсгийг 13 хүний бүрэлдэхүүнтэй байхаар тус тус олонхийн саналаар шийдвэрлэж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд өргөн барихыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Д.Дэлгэрбаярт үүрэг болгов.
4	Хөрөнгө гаргах тухай захирамжийн төсөл	Хөрөнгө гаргах захирамжинд 2348500 төгрөгийг зарцуулж аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг зөвшөөрч олонхийн саналаар шийдвэрлэв.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН 08 ДУГААР ХУРАЛ

Хурлыг 2014 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 16 цаг 45 минутад эхэлж, 18 цаг 22 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын өрөөнд болж, 1 цаг 37 минут хуралдав.

д\д	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Гэр бүлийн хөгжлийн хөтөлбөрийн төсөл хэлэлцүүлэх тухай	Гэр бүлийн хөгжлийн хөтөлбөрийн төслийг богино хугацаанд олон нийтийг хамарсан хэлэлцүүлэг зохион байгуулж, дахин боловсруулж хурлаар хэлэлцүүлэхийг Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн дарга Л.Энхбаярт үүрэг болгов.
2	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 04 дүгээр хуралдааны	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр Жаргалант сумын иргэн Б.Энх-Амгаланд нэг сая төгрөгийн

	тэмдэглэлийн тухай	тусламж олгох эрх зүйн зохицуулалт байхгүй тул аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд албан тоотоор хариу өгөхийг Хууль зүйн хэлтсийн дарга Ж.Дөлбадрахад үүрэг болгов.
3	Аймгийн Прокурорын газар Прокурорын мэдэгдэлийн тухай	Аймгийн Засаг даргын албан даалгавар боловсруулан батлуулж, сум байгууллагуудад хүргүүлж хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хууль зүйн хэлтсийн дарга Ж.Дөлбадрахад үүрэг болгов.
4	Ёслол хүндэтгэлийн өргөө байгуулах тухай	Ёслол хүндэтгэлийн өргөөний байгуулах саналыг дэмжиж, хөрөнгийн асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр саналаа хүргүүлэхээр тогтов.
5	Улсын тэргүүний сум шалгаруулах болзол хангасан сумыг танилцуулах тухай	2013 оны ажлаараа аймагт нэгдүгээр байрт шалгарсан Үенч сумыг улсын тэргүүний сумын шалгаруулалтад оруулахаар дэмжиж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд уламжлахаар тогтов.
6	Хөрөнгө гаргах тухай захирамжийн төсөл	Хөрөнгө гаргах захирамжинд 3905920 төгрөгийг зарцуулж аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг зөвшөөрч олонхийн саналаар дэмжиж шийдвэрлэв.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН 09 ДҮГЭЭР ХУРАЛ

Хурлыг 2014 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 13 цаг 45 минутад эхэлж, 18 цаг 20 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын өрөөнд болж, 4 цаг 35 минут хуралдав.

Д Д	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Аймгийн сайн малчин шалгаруулах журмын 3.8, аймгийн тэргүүний тариаланч, тэргүүний тариаланч хамт олон шалгаруулах журмын 2.12, аймгийн тэргүүний фермер шалгаруулах журмын 4.8, аймгийн тэргүүний малчдын бүлэг шалгуулах журмын 4.18 дахь хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулах тухай	Аймгийн Засаг даргын 2009 оны 167 дугаар захирамжаар баталсан аймгийн “Сайн малчин” шалгаруулах журмын 3.8, аймгийн “Тэргүүний тариаланч, тэргүүний тариаланч хамт олон” шалгаруулах журмын 2.12, аймгийн “Тэргүүний фермер” шалгаруулах журмын 4.8, аймгийн “Тэргүүний малчдын бүлэг” шалгаруулах журмын 4.18 дахь заалтуудад тус салбарын аваргаар нэр дэвшигч нь хүмүүнлэгийн үйлсэд тодорхой хувь нэмэр оруулж, аймгийн Улаан загалмайн санд 200000 төгрөгөөс доошгүй хандивыг хандивласан байх гэж нэмэлт шалгуур үзүүлэлтийг тус тус журамд нэмэлт өөрчлөлтөөр тусгахыг Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга З.Эрхбаярт үүрэг болгов.

2	Махны нөөц бүрдүүлж үнэ тогтворжуулах хөтөлбөрийн төсөл хэлэлцэх тухай	1.Махны нөөц бүрдүүлж үнэ тогтворжуулах хөтөлбөрийн 3.8, 3.9 дэх хэсгийг хасах 2. Хөтөлбөрийн 2.1.4 дэх хэсэгт жил бүр махны нөөц бүрдүүлж, үнийг тогтворжуулан, нөөцийн санг 300 сая төгрөг хүртэл бүрдүүлж ажиллах 3.Хөтөлбөрийн 4.1.5 дахь хэсэгт Орон нутгийн хөрөнгөөр махны нөөц бүрдүүлж үнэ тогтворжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх сан бүрдүүлж ажиллана гэж тус тус нэмэлтээр тусгаж, хөтөлбөрийн утга, найруулгыг засварлан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга З.Эрхбаярт үүрэг болгов
3	Аймгийн Хяналт-шинжилгээ үнэлгээний 2013 оны тайлан	Хяналт- шинжилгээний үнэлгээ, тайланг санал нэгтэй дэмжиж хугацаанд нь ЗГХЭГ-т хүргүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ үнэлгээний тасгийн дарга Ц.Оюунцэцэгт үүрэг болгов.
4	Төрийн үйлчилгээний чанар хүртээмжид өгсөн хэрэглэгчийн үнэлгээ	Төрийн байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжид өгсөн хэрэглэгчийн үнэлгээний дагуу гарсан зөвлөмж, хийгдэж байгаа ажлуудын явц, гүйцэтгэлд иргэдийн хөндлөнгийн үнэлгээ хийлгэн саналыг үндэслэн үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг хэлтэс, тасгийн дарга нарт үүрэг болгов.
5	Булган сумын Булган голын тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн заагийг өргөтгөх тухай	Булган гол-Их Онгогийн БЦГ-ын хилийн заагийг өргөтгөх тухай багийн Иргэдийн Нийтийн Хурал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолууд, сумын саналыг дэмжин аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга З.Эрхбаярт үүрэг болгов.
6	Хөрөнгө гаргах тухай захирамжийн төсөл	Хөрөнгө гаргах захирамжинд 2799000 төгрөгийг зарцуулж аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг зөвшөөрч олонхийн саналаар дэмжив.

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН 10 ДУГААР ХУРАЛ**

Хурлыг 2014 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 08 цаг 20 минутад эхэлж, 10 цаг 25 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын өрөөнд болж, 2 цаг 05 минут хуралдав.

д	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Аймгийн газар зохион байгуулалтын 2013 оны төлөвлөгөөний биелэлт, 2014 оны газар зохион байгуулалтын 2014 оны төлөвлөгөөний тухай	<p>1.Нэгдүгээр хавсралтын “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зориулалтаар эзэмшүүлэх, газрын байршил, хэмжээ, хөрөнгө оруулалт”-ын Бичигт багийн Дулааны станцын зүүн талын 0,82 га газрыг Дөл түлшний зах гэснийг Нүүрс түлшний худалдааны захын зориулалтаар гэж засварлах</p> <p>2.Нэгдүгээр хавсралтын “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зориулалтаар эзэмшүүлэх, газрын байршил, хэмжээ, хөрөнгө оруулалт”-ын Бичигт багийн Элсэн толгойн хойд талын Шахмал түлшний үйлдвэрийг дуудлага худалдаагаар гэснийг төсөл сонгон шалгаруулалтаар гэж засварлах</p> <p>3.Нэгдүгээр хавсралтын “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зориулалтаар эзэмшүүлэх, газрын байршил, хэмжээ, хөрөнгө оруулалт”-ын Бичигт багийн Элсэн толгойн урд талын Нүүрсний төвлөрсөн цэгийг дуудлага худалдаагаар гэснийг төсөл сонгон шалгаруулалтаар гэж засварлах</p> <p>4.Нэгдүгээр хавсралтын “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зориулалтаар эзэмшүүлэх, газрын байршил, хэмжээ, хөрөнгө оруулалт”-ын Жаргалант сумын Магсаржав багийн Нийтийн номын сан 24 айлынорон сууц хоёрын дунд 0.02 га газрыг үйлчилгээний зориулалтаар дуудлага худалдаагаар гэснийг хасах</p> <p>5.Замын улаан шугамд орж байгаа газрыг өмчлөхгүй байх</p> <p>6. Арван нэгдүгээр хавсралтын “ Газрын элэгдэл, эвдрэл, доройтлоос хамгаалах нөхөн сэргээх газрын байршил, хэмжээ”-ний Жаргалант сумын Цамбагарав багийн Их голын ард нөхөн сэргээх 5 га газрыг хасах</p> <p>7.Шинэ суурьшлийн бүсийн замын зүүн талд ШТС-ын газрыг дуудлага худалдаагаар олгохоор нэмэлтээр тусгах</p> <p>8.Илтгэлд газрын талаарх төрийн бодлого, орон нутгаас баримталж байгаа бодлого чиглэл, аймгийн ИТХ-аас газрын зөрчил маргааны талаар өгсөн үүрэг чиглэлийн биелэлт, газрын маргааныг шийдвэрлэсэн талаар хийсэн ажил, газар эзэмшил, өмчлөлийн хэрэгжилт, үр өгөөжийг дээшлүүлэх, 2014 онд баримтлах бодлого чиглэлийн тусгаж дэлгэрэнгүй бичих</p> <p>9.Аймгийн ерөнхий төлөвлөгөөний дагуу Ховд их сургуулийн тэнхимтэй хамтран ангийн ажил, дипломын ажлаар аймгийн болон хэсэгчилсэн макет хийлгэх болзол зарлах</p>

<p>10.Хоёрдугаар хавсралтын “Хууль бус газар эзэмшилтийн талаар авах арга хэмжээ”-ний Жаргалант сумын Буянт багийн 19 дүгээр гудамжны 1,3 га газрыг мэдэгдэх хуудас, газар чөлөөлөх гэснийг нэмэлтээр хашаа, гэр, иргэдийн судалгааг гаргаж танилцуулах</p> <p>11.Аймгийн газар зохион байгуулалтын 2013 оны төлөвлөгөөний биелэлт, газар зохион байгуулалтын 2014 оны төлөвлөгөөний төсөлд гарсан саналуудыг тусгаж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга Ч.Пүрэвдоржид үүрэг болгов.</p>

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР